



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 13

Номгон

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5, ахь хэсгийн “д”, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд ажил үйдэл, ядуурлыг бууруулах, хөдөлмөрийн таатай орчин, хөдөлмөрийн зах зээл дэх тэгш боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай орлоготой болгох зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг 2017-2021 онд хэрэгжүүлсүгэй.


2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дугээр сарын 18-ны
өдрийн 13 дугаар тогтоолын хавсралт



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Ажиллах хүчний өнөөгийн байдал

Баянхонгор аймгийн нийт хүн ам 2016 оны жилийн эцсийн байдлаар 85331 болж, үүнээс нийт хүн амын 32.1 хувийг 16 хүртэл насны хүүхэд 27440, 62 хувийг хөдөлмөрийн насныхан 52942, 5.2 хувийг өндөр настан эзэлж байна. Хөдөлмөрийн насны 52942 хүн амын 47 хувь буюу 40109 хүн хөдөлмөр эрхэлж байна. Үүнээс 1003 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хөдөлмөр эрхэлж байна.

Нийт ажиллагсдын 49.06 хувь буй 19678 хүн нь эмэгтэйчүүд байна. Нийт ажиллагсдын 61.7 хувь нь ХАА-н салбарт, 4.0 хувь нь уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт, 3.0 хувь нь боловсруулах аж үйлдвэрийн салбарт, 0.9 хувь нь цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт, 3.5 хувь нь барилгын салбарт, 6.7 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар үйлчилгээний салбарт, 1.2 хувь нь зочид буудал, зоогийн газрын салбарт, 1.8 хувь нь тээвэр, агуулах, холбооны салбарт, 1.0 хувь нь санхүүгийн салбарт, 1.4 хувь нь үл хөдлөх хөрөнгө, бизнесийн бусад салбарт, 4.2 хувь нь төрийн удирдлага, батлан хамгаалах, 6.8 хувь нь боловсролын салбарт, 2.2 хувь нь эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт, 1.6 хувь нь нийгэм, бие хүнд үйлчилгээ үзүүлэх салбарт ажиллаж байна.

Орон нутгийн хэмжээнд ажил хөдөлмөр эрхлээгүй нийт 3762 иргэнээс 2354 эмэгтэй, үүнээс бүртгэлтэй ажилгүй иргэд 1515 байгаас 56.6 хувь буй 859 хүн эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 237 суурь, 606 бүрэн дунд боловсролтой, 106 хүн техникийн болон мэргэжлийн тусгай мэргэжлийн, 351 хүн дипломын болон дээд боловсролтой хүмүүс байна.

Аймгийн хэмжээнд 24821 өрхтэй болж түүний 48.9 хувь нь төв суурин газарт, 51.1 хувийг нь хөдөөгийн өрх эзэлж байна.

Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн 3416 үүнээс хөдөлмөрийн насны 3201 байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 4057 бүртгэгджээ.

Аймгийн ажилгүйдлийн нийгмийн үр дагавар нь хүмүүсийн ирээдүйдээ итгэх итгэл алдарч, сахилга, дэг журам супарч, хүн өөрийгөө хөгжүүлэх боломж хязгаарлагдаж, боловсрол, эрүүлийг хамгаалах, соёл урлагийн болон нийгмийн бүхий л үйлчилгээ авахад бэрхшээлтэй болж хүн бүрт, өрх бүрт хүчтэй нөлөөлдөг.

Харин ажилгүйдлийн эдийн засгийн үр дагавар нь ажиллах хүчний нөөц бололцоог дутуу ашигласнаас хүмүүс нийгэмдээ болоод өөртөө баялаг бүтээх боломжкоо эрэлт буцалтгүйгээр алддаг.

Гэтэл хөдөлмөрийн зах зээлд шилжин орж буй хүмүүсийг ажилтай болгох, ажлын байрны хүртээмж хангалтгүйгээс их дээд сургууль төгссөн болон мэргэжил эзэмшсэн залуучууд ажилгүйчүүдийн эгнээнд шилжин аймгийн ажилгүйдлийн түвшинг нэмэгдүүлж байна.

Иймд ажиллах хүчний багтаамжтай үйлдвэрүүдийг бий болгох, төрийн албанад ажиллаж буй тэтгэврийн насны хүмүүсийг тэтгэвэрт нь хугацаанд нь гаргаж байх, бүлэг, хоршоо, нөхөрлөл, аж ахуй нэгж үүсгэн ажиллаж байгаа иргэдэд хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлснээр ажиллах хүчинг ажлын байраар хангах боломж байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчоос мэргэжилтэй ажилтанд тавьж буй мэдлэг, ур чадварын хэрэгцээг хангасан мэргэжилтэй ажилтанг бэлтгэх орчин бүрдэж чадахгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн албанад одоогоор бүртгэлтэй байгаа ажилгүйчүүд 1515 байгаагийн 56,6% буюу 859 иргэн нь эмэгтэйчүүд, 63,8% буюу 967 тодорхой эзэмшсэн мэргэжилгүй ажилгүйчүүд, 57,8% буюу 876 иргэн нь 20-35 насныхан, 42,1% буюу 639 иргэн нь 35-аас дээш насны удаан хугацаагаар ажил эрхлээгүй эмзэг бүлгийн иргэд эзлэж байна.

ХОЁР. ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ШААРДЛАГА

Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий төлөв нь ажиллах хүчний урсгал хөдөлгөөн ихтэй, бүтээмж багатай, зах зээлд ажиллах хүчний өрсөлдөх чадвар муу, мэргэжилгүй ажилгүйчүүдийн эзлэх хувь өндөр, гар аргаар алт олборлогч иргэд олонтой, байгалийн нөхөн сэргээлт хийдэггүй, ихэнх сумын нутагт цөлжилт эрчимтэй явагдаж байгаа, ажиллах хүчнийг шингээх жижиг, дунд үйлдвэрлэл хөгжөөгүй гэсэн гол шинж чанараар тодорхойлогдож байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт байхгүйгээс их, дээд сургууль, MCYT болон Политехник коллеж, дамжаа төгссөн залуучууд ажлын байраар хангагдахгүй байна.

Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж аливаа сургалт, бодлого, хөтөлбөр арга хэмжээнд жендэр талаас нь дүн шинжилгээ хийх, хяналт тавих бодлого үгүйлэгдэж байна.

Дээд, болон мэргэжлийн боловсролтой ажилгүй иргэд нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 30 гаруй хувийг эзлэж байгаа нь тэдний мэргэжил ур чадварт нь таарч тохирох ажилд зуучлах, мэдээллээр хангах, тусгайлсан бодлого арга хэмжээгээр дэмжих нийгмийн захиалга гарч байна. Мөн хөдөлмөрийн зах зээлийн багтаамжийн нарийвчилсан судалгаа зайлшгүй үгүйлэгдэж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг бодитой болгох,

ажил олгогч, эзэд, мэргэжлийн холбоод, сургалтын байгууллагуудын хамтын ажиллагааны зохицтой хэлбэрийг бий болгох шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд болон төрийн байгууллагуудад хүний нөөцийн хөтөлбөр төлөвлөгөө байхгүй, их, дээд сургуулиудад орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн захиалгат мэргэжилтнүүдийг бэлтгэдэггүй, төгсөж ирсэн чадварлаг мэргэжилтнүүдийг бүртгэх, тэднийг ажлын байраар хангах бодлого байхгүй байна.

Мөн Төрийн албаны шалгалтад Хөдөлмөрийн хэлтэст /хуучин нэрээр/ бүртгэлтэй иргэдийг оруулах талаар бодлого байхгүй зэргээс болж боловсон хүчнийг бүртгэх, ажилд зуучлах, зохицуулах зэрэг үйлчилгээ стандартын дагуу явагдах боломж бүрдээгүй байна.

Иймд дээрх хэрэгцээ, шаардлагад тулгуурлан 2017-2021 оны хугацаанд хэрэгжүүлэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн хөтөлбөр боловсруулав.

**ГУРАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО,
АЛСЫН ХАРАА, БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

3.1 Хөтөлбөрийн эрхэм зорилго

Баянхонгор аймгийн хэмжээнд байгаа ажилгүйдэл ядуурлыг бууруулах, хөдөлмөрлөх таатай орчин болон хөдөлмөрийн зах зээл дэх тэгш боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай орлоготой болгоход оршино.

3.2 Хөтөлбөрийн алсын хараа

Баянхонгорын иргэн бүр хөдөлмөрлөх эрх сонголтоор хангагдаж, өндөр технологид суурилсан хувийн хэвшилд түшиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээг эрчимтэй хөгжүүлсэн, тогтвортой, мэдлэгт суурилсан эдийн засагтай, иргэн бүр ажилтай орлоготой, хангайн бүсийн тэргүүлэх аймаг болно.

3.3 Баримтлах зарчим

Хөтөлбөрийг дор дурдсан үндсэн зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлнэ.

3.3.1 Хүүхэд, залуучуудад хөдөлмөрийг үнэлэх, хүндэтгэх, тогтвортой орлогыг амьжиргааны үндсээ гэж дээдлэх үзлийг төлөвшүүлэх

3.3.2 Ажил, хөдөлмөр эрхэлж орлого бий болгох нь ядуурлаас гарах гол арга зам гэдгийг иргэн бүрт ухамсарлуулах

3.3.3 Ажлын дадлага, мэргэжил, мэргэжлийн өндөр ур чадвар эзэмших нь хүн бүрийн хөдөлмөр эрхлэх үндсэн нөхцөл болохыг ойлгуулах

3.3.4 Орон нутгийн давуу тал, өвөрмөц онцлог, бусчилсэн хөгжлийн ирээдүйн чиг хандлага, хөрөнгө оруулалттай нягт уялдуулах

3.3.5 Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулахад өмчийн бүх хэвшлийн аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог идэвхжүүлж, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах, нийгмийн зөвшлийг хөгжүүлэх

3.3.6 Өрх гэр бүлээрээ болон бүлэг, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр зохион байгуулалттай хөдөлмөр эрхлэх, зохистой ажлын байр бий болгох иргэд, ААН, ТББ-ын санал, санаачлагыг илүүтэй дэмжих

3.3.7 Албан бус салбарт ажиллагсдыг албан ёсны статустай болгож, ААН-ын хэлбэрээр ажил, үйлчилгээ эрхэлж зохистой ажлын байр нэмэгдүүлэхийг дэмжих

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ, ҮР ДҮН, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аймгийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн нөөц, баялагт суурилсан ажиллах хүчинг шингээсэн хөдөө аж ахуй, хүнд, хөнгөн үйлдвэрлэл, аялал жуучлалыг хөгжүүлж, уул уурхайн бүтээгдэхүүн болон барилгын материалын түүхий эдэд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжлийн тэргүүлэх чиглэл гэж үзнэ.

Зорилт-1 Бэлтгэгдсэн мэргэжилтэй ажилтны зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулан, хүний амьдралын чанар, аюулгүй байдлыг сайжруулах

Үр дүн: Бэлтгэгдсэн мэргэжилтэй ажилтанг зохистой ажлын байранд зуучилж, хөдөлмөрлөх эрхийг хангасан байна.

Зорилт 1-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа. Үүнд:

1.1.1 Зорилтот бүлэгт амьдрах арга ухаанд сургах тодорхой хөдөлмөр эрхлэх чадвар эзэмшүүлэх үйлчилгээ

1.1.2 Мэргэжилтэй ажилтнаар бэлтгэгдсэн иргэдийг ижил хэрэгцээ, сонирхол, хувь хүний хандлага эрмэлзлээр нь нэгтгэн зохион байгуулж, олон нийтийн оролцоонд тулгуурласан зорилтот бүлэг зохион байгуулах замаар хөдөлмөр эрхлүүлэх

1.1.3 Үр чадвар эзэмшсэн мэргэжилтэй ажилтанд өрхийн үйлдвэрлэл, аж ахуй эрхлэлт, хоршоо нөхөрлөл байгуулан ажиллахад нь дэмжлэг үзүүлэх

1.1.4 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн зорилтот бүлгүүдэд үзүүлэх аж ахуй эрхлэлтийн үйлчилгээний төрөл хэлбэрийг тодорхойлж, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэн хэрэгжүүлэх

1.1.5 Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээгээр дамжуулан ЕБС-ийн суралцагчдад, ажил хайгч иргэдэд ажил мэргэжлийн зөвлөгөө өгч, мэдээллээр хангах

1.1 Мэргэжилтэй ажиллах хүчинг төрийн байгууллагад зуучлах үйлчилгээ

1.2.1 Төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдын ажлын бодит үр дүнтэй нь холbon дүгнэж, ажлын байрны шаардлага хангахгүй байгааг нь ажлаас чөлөөлөх, тэтгэврийн насанд хүрсэн албан хаагчдыг тэтгэвэрт гарган төрийн албанад бүртгэлтэй мэргэжилтэй ажиллах хүчинг ажлын байранд зуучлах

1.2.2 Төрөөс гаргасан ажлын байранд тэнцэж ажиллах чадвартай боловсон хүчинг бэлтгэдэг сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах

1.2.3 Ажил олгогчид дэмжлэг үзүүлж, мэргэжилтэй ажилтанг зохистой ажлын байранд зуучлах үйлчилгээ

1.2.4 Томоохон аж ахуй нэгж байгууллагуудыг түшиглэн үйлдвэрлэл дээрх сургалтын төв байгуулах орчин бүрдүүлж, сургалтын эрх авах болон чадварлаг ажилтан бэлтгэсэн ажил олгогчидтой хамтран ажиллах

1.2.5 Тухайн жилд хамгийн олон ажлын байр бий болгож, бэлтгэгдсэн мэргэжилтэй ажилтанг ажлын байраар хангасан ажил олгогчдыг урамшуулах системийг бүрдүүлэх

1.2.6 Мал төллөх үеээр малчдын хүүхдийг асрах “Хувилбарт” цэцэрлэгийг сум бүрт байгуулж ажлын байрыг нэмэгдүүлэх

Зорилт-2 Хүн амын зорилтот бүлгүүдийн хөтөлбөрүүдэд тусгагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх

Үр дүн: Хөтөлбөр төслүүдийн хүрээнд байнгын ажлын байртай болсон иргэдийн тоо нэмэгдсэн байна.

Зорилт 2-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа. Үүнд:

2.1 Зорилтот бүлгийн иргэдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамруулж, хөдөлмөр эрхлэлтийн идэвхтэй бодлогоор дэмжих

2.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

2.3 Олон нийтийн оролцоонд тулгуурласан нийгмийн үйлчилгээг хөгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

2.4 40-өөс дээш насны хөдөлмөрийн чадвартай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг судалж хэрэгжүүлэх

2.5 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд өөрийн мэргэшсэн чиглэлээр ажлын байр бий болгох санал, санаачлагыг дэмжих

2.6 Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөр боловсруулан батлуулж хэрэгжүүлэх

2.7 Гадаадад ажиллаад шинэ техник технологи эзэмшсэн залуучуудын үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих

2.8 Малчин өрхүүдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулан тэдний аж ахуй эрхлэх ур чадвар, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг дэмжих

2.9 Зорилтот бүлгийг түр ажлын байраар хангаж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх

2.10 Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар эзэмшүүлж, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, ажлын байрыг дэмжих

Зорилт-3 Хүүхэд залуучууд, ажилгүй иргэдэд мэргэжил сонгоход шаардлагатай ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээлэл зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх энэ чиглэлийг үйлчилгээг хөгжүүлэх

Үр дүн: Орон нутгийн хэмжээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний ойлголт хандлагыг төлөвшсөн байна.

Зорилт 3-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа. Үүнд:

3.1. Аймгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан орон нутгийн эрэлттэй ажил мэргэжлийн судалгааг гаргаж, бодлого боловсруулах түвшинд болон бусад салбарт ашиглах

3.2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах

3.3. ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын эцэг эхчүүдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх сургалт хийх

3.4. Ажилгүй иргэд болон зорилтот бүлгийн иргэдэд хөдөлмөрт бэлтгэх сургалт, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгээр зохион байгуулах

3.5. Ажил мэргэжлийн онцлогоор ажил мэргэжлийг танилцуулах аялал хийх, видео, мэргэжлийн тоглолт, өдөрлөгийг зохион байгуулж ажиллах

3.6. Хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага, ажлын байр, ажилтны мэдлэг ур чадварт тавигдах шаардлагад шинэ эрэлт хэрэгцээг уялдуулан зөвлөгөө өгөх, сургах зорилгоор алдартнуудтай уулзалт ярилцлага хийх

3.7. Зорилтод бүлгийн иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгож, бизнестэй холбон, ажлын байраар хангах төслийг хэрэгжүүлэх

Зорилт-4 Иргэдийн бизнес эрхлэх мэдлэг чадварыг хөгжүүлж, хөрөнгө оруулалтаар зохистой ажлын байр бий болгож, өрхийн орлогыг нэмэгдүүлэх хөдөлмөр эрхлэх таатай орчинг бүрдүүлэх

Үр дүн: Иргэдийн бизнес эрхлэх мэдлэг чадвар дээшилж, зохистой ажлын байр бий болж, өрхийн орлогыг нэмэгдэнэ.

Зорилт 4-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа. Үүнд:

4.1. Гэр бүлээрээ нийлэн хөдөлмөрөө хоршин хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх

4.2. Өндөр боловсрол мэргэжил эзэмшсэн залуучуудыг орон нутагтаа ирж ажиллах боломж хөшүүргийг судалж хэрэгжүүлэх

4.3. Орон нутгийн гар урчуудын онцлогийг харуулсан гар урлалын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, дотоод гадаадад борлуулахад дэмжлэг үзүүлэх

4.4. Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох сургалтыг зохион байгуулж, мэргэжил, мэргэжлийн ур чадвар эзэмших хүсэлтэй иргэдийг хамруулах

4.5. Бүлэг хоршоо, нөхөрлөл үүсгэн байгуулах, хамтран ажиллах сургалт, туршлага солилцох аялал зохион байгуулах

4.6. Жил бүр шилдэг нөхөрлөл, бүлэг, хоршоог шалгаруулан урамшуулах, тэдний сайн туршлагыг түгээх

4.7. "Хуримтлалтай хонгорчууд" төслийг боловсруулан хэрэгжүүлэх

Зорилт-5 Ашиглаад орхисон талбайд биологийн нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгж байгууллага, бүлэг иргэдийн санал санаачлагаар "Ногоон Баянхонгор" аян өрнүүлэх замаар түр ажлын байруудыг бий болгох

Үр дүн: Иргэд эрүүл аюулгүй орчинд ая тухтай ажиллаж амьдрах нөхцөл боломж бурдэнэ.

Зорилт 5-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа. Үүнд:

5.1. Одоо ашиглагдаж байгаа уул уурхайн компаниудын 50-аас доошгүй хувьд орон нутгийн иргэдийг ажиллуулж ажлын байраар хангах

5.2. Бичил уурхайг хөгжүүлж, гар аргаар алт олборлогчдыг бүлэг, нөхөрлөл болгон бүртгэлтэй ажлын байраар хангаж, хөдөлмөрийн харилцааны асуудлыг шийдвэрлэх

5.3. Ашиглаад орхисон талбайд биологийн нөхөн сэргээх төсөл санаачлагыг дэмжиж, тэдгээрт ажилгүй иргэдийг ажиллуулах

5.4. Бичил уурхай эрхлэгчдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх сургалт зохион байгуулж, үйлдвэрлэлийн осол гэмтлийг бууруулах

5.5. Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдийн нийгмийн хариуцлагыг тодорхой болгож, "Нэг уурхай-нэг үйлдвэр" төслийг хэрэгжүүлж, ажлын байрыг бий болгох

5.6. Уул уурхайн ашиглалтын компаниудтай гэрээ байгуулан, ХАМО иргэдэд газар олгож байнгын орлоготой болгож ажлын байраар ханган, амьжиргааг дэмжинэ.

Зорилт-6 Гадаад болон дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, иргэдийг ажлын байраар хангах

Үр дүн: Гадаад болон дотоодын аялал жуулчлалыг хөгжиж, тодорхой хэмжээний ажлын байр бий болгоно.

Зорилт 6-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа. Үүнд:

6.1. Аялал жуулчлалын шинэ маршрут, чиглэлийг бий болгох санаачлагыг дэмжих

6.2. Жуулчны суурин болон нүүдлийн бааз байгуулж ажлын байр бий болгох

6.3. Шаргалжуут рашаан сувилал, Цагаан агуй, Бичигт хадны маршрутын байнгын аялах нөхцлийг бүрдүүлж байнгын ажлын байр бий болгох

6.4. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлэх

6.5. Гадаадын болон дотоодын аялагчдын сонирхлыг татахуйц Баянхонгор нутгийн онцлогтой Хонгор нутагт үйлдвэрлэсэн бэлэг дурсгалын үйлдвэрлэлийг хөгжүүлж ажлын байрыг бий болгох

6.6. “Аялал жуулчлалыг хөгжүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлж, амралт жуулчны цогцолбор, “Хот айл-жуулчны бааз” зэрэг үйлчилгээг хөгжүүлж ажлын байрыг бий болгоно.

Зорилт-7 Мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнд түшиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэн зохистой ажлын байрыг нэмэгдүүлж, өрхийн амьжиргааг дээшлүүлэх

Үр дүн: Мал аж ахуй, газар тариалан, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд түшиглэсэн ажлын байр нэмэгдсэн байна.

Зорилт 7-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа. Үүнд:

- 7.1. “Шинэ хөдөө” хөтөлбөр хэрэгжүүлж, хөдөөгийн ард иргэдээ хөгжүүлнэ.
- 7.2. Max сүүний үйлдвэр байгуулж ажлын байрыг нэмэгдүүлэх
- 7.3. Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг боловсруулах хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдыг дэмжиж ажлын байр бий болгох
- 7.4. Малчид, жижиг дунд бизнес эрхлэгчдийн “Хадгаламж зээлийн хоршоо”-г байгуулахад дэмжлэг үзүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх

7.5. Ноос, ноолуур угаах, анхан шатны боловсруулалт хийж, экспортлох жижиг дунд үйлдвэрлэлийг байгуулах

- 7.6. Эсгий, эсгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг өрхийн үйлдвэрлэгчдийг дэмжих
- 7.7. Max, сүүний чиглэлээр фермерүүдийг бий болгох
- 7.8. Малчдыг бизнес эрхлэгч хэмээн үзэж байгалийн гаралтай бордоо үйлдвэрлэх, тэжээлийн өндөр нэгжтэй ургамал тариалах үйл ажиллагааг дэмжиж ажлын байрууд бий болгох

Зорилт-8 Баянхонгор аймгийг үйлдвэржүүлэх нэгдсэн бодлого гарган зохистой ажлын байраар хангах

Үр дүн: Баянхонгор аймгийг үйлдвэржүүлэх нэгдсэн бодлогын хүрээнд байнгын ажлын байртай болсон иргэдийн тоо нэмэгдсэн байна.

Зорилт 8-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа. Үүнд:

- 8.1. Цементийн үйлдвэрлэл байгуулж, орон нутгийн болон баруун бүс нутгийн хэрэгцээг хангах
- 8.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордуудыг ашиглалтад оруулж керамик, полимер чулуун эдлэлийн үйлдвэр байгуулж бүс нутгийн хэрэгцээг хангах
- 8.3. Улаанбаатар хотоос баруун аймгийн чиглэлийн хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замын дагуу олон улсын стандартад нийцсэн үйлчилгээний иж бүрэн

төвүүдийг хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулж тухайн бүс нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх “Баруун зам” төслийг хэрэгжүүлнэ.

8.4. Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх дунд хугацааны хөгжлийн стратеги бодлогын баримт бичигт туссаны дагуу аймгийн төвөөс 50 км-ийн тойрот өндөр ашиг шимтэй, мах сүү, гахай, тахианы чиглэлийн фермерийн аж ахуйг хөгжүүлэх, тэдгээрийг тэтгэсэн малын тэжээлийн ургамал тариалах, тэжээл үйлдвэрлэх бодлогыг кластрийн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлнэ.

8.5. Жил бүр 50-иас доошгүй газар уст цэгийн хайгуул хийж, 20-иос доошгүй гүн өрмийн худаг гаргаж, гар худаг гаргаж буй иргэдийг төрийн бодлогоор дэмжинэ.

8.6. Малчдын залуу халааг бэлтгэх “Илгээлтийн эзэн” хөтөлбөрийг хэрэгжүүлж малжуулах төслөөр дэмжинэ.

8.7. Газар тариалан эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, зах зээлийг нь хамгаалах бодлого хэрэгжүүлж, өвөл зуны хүлэмж бүхий агропарк байгуулан нарийн ногоо, жимс жимсгэнэ, хүнсний ногоо тариалах, үр, хүнсний ногооны өндөр технологи бүхий зоорь байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.

8.8. Утаагүй түлшний үйлдвэрлэл эрхлэх аж ахуй нэгж, иргэдийг дэмжинэ.

8.9. Сум бүрт хог боловсруулах жижиг үйлдвэр байгуулж, хоёрдогч түүхий эдийг ашиглах, байгаль экологид ээлтэй цаасан уут, сав баглаа боодлын болон даавуун уутны жижиг үйлдвэрлэл бий болгож гялгар, нийлэг уутны хэрэглээг хална.

8.10. Аймгийн төвд дулааны станц барьж агаарын бохирдол, утааны асуудлыг багасгахын зэрэгцээ хэрэглээний халуун усны төвлөрсөн системтэй болж, хуучирсан инженерийн шугмыг шинэчлэх, өргөтөх, инженерийн шугам тавигдсан 3, 6, 7, 9 дүгээр багуудын айл өрхүүдийг холбоно.

8.11. Баянхонгор-Эрдэнэцогт-Архангай чиглэлийн орон нутгийн чанартай авто замуудыг барьж, Цагаан туруутын голд төмөр бетон гүүр барьж, Өртөмт, Хүрэмтийн голын гүүрийг шинэчлэн засварлана.

8.12. Орон нутгийн нөөц баялагт түшиглэн Үүдийн давс, Холбоожын давсыг нөөцөлж түр ажлын байр бий болгох

8.13. Арьс, ширэнд анхан болон дунд шатны боловсруулалт хийх үйлдвэрлэл байгуулж ажлын байр бий болгох

8.14. Байдраг хонины ноосонд анхан шатны боловсруулалт хийх үйлдвэрлэлийг Жаргалант суманд байгуулж ажлын байрыг нэмэгдүүлэх

8.15. Сүү, сүүн бүтээгдэхүүнийг болон савлах үйлдвэрлэлийг хөгжүүлж ажлын байр нэмэгдүүлэх

8.16. Өрхийн хэмжээнд буюу хашаандаа газар тариалан эрхэлж байгаа өрхүүдийн хамтран ажиллах санаа санаачлагыг дэмжиж, сайн сортын үрээр хангаж өрхийн орлогыг нэмэгдүүлэх

8.17. Газар тариалан эрхлэх иргэд шинээр газар олгох, шинэ сортын үр, технологиор дэмжих

8.18. Үр тариа, тэжээлийн ургамал, малын тэжээл тариалах иргэдэд санхүүгийн дэмжлэг олгох

8.19. Газар тариалангийн үйлдвэр эрхлэгч, иргэд болон аж ахуйн нэгжүүдийг дэмжиж өрхийн орлого нэмэгдүүлэх

8.20. Хүлэмжийн аж ахуй хөгжүүлж ажлын байр бий болгох

8.21. Газар тариалан эрхлэгчдийн дунд ургац хураалтын үеэр "Ургацын баяр" үзэсгэлэн худалдаа зохион байгуулах

Зорилт-9 Хүн амын өргөн хэрэглээг хангах ахуйн үйлчилгээний цогц үйлчилгээг бий болгож, ажлын байр гарах

Үр дүн: Хүн амын өргөн хэрэглээг хангаж, ахуйн үйлчилгээний цогц үйлчилгээг бий болж, ажлын байр бий болно.

Зорилт 9-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа. Үүнд:

9.1. Сумын төвд авто болон хөдөө аж ахуйн машин механизмын засварын төв байгуулж ажлын байр бий болгох

9.2. Сумын төвүүдэд гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, гар утас, компьютерын засвар үйлчилгээг хөгжүүлж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх

9.3. Гадаад болон дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг борлуулахад дэмжлэг үзүүлэх, хөтөлбөр төсөлд хамруулах

9.4. Хүмүүл, таана, байгалийн хадланг ашиглан нутгийн брэнд тэжээл үйлдвэрлэх санаа санаачлагыг дэмжих

9.5. Малын ялгадас, нүүрсний хог модны үртсийг ашиглан шахмал түвш үйлдвэрлэж ажлын байр бий болгох

9.6. Ахуйн хогийг ангилж бэлтгэх, боловсруулах төслүүдийг дэмжих

9.7. "Айл хотлоороо үйлдвэрлэгч" уриан дор өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байруудыг бий болгон, өрхийн орлогыг дээшлүүлж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээг бий болгох

9.8. Барилга, уул уурхай зэрэг томоохон салбаруудад ажиллагсдын хэрэгцээт хөдөлмөр хамгааллын хувцас, бусад хэрэгслийг орон нутгийнхаа үйлдвэрлэгчидтэй холбох

Зорилт-10 Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт зохион

байгуулах аж ахуйн нэгж, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, сургалт сурталчилгаа хийх.

Үр дүн: Хөдөлмөрийн харилцаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, хууль эрх зүйн хэрэгжилт сайжирч, эрсдэлгүй, аюулгүй, эрүүл ажлын байрны орчинг бий болж, ажил олгогчид зөрчилгүй, ажиллагсад аюулгүй ажиллах зан үйл, соёл төлөвшиж, чадавх бэхжэксэн байна.

Зорилт 10-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа. Үүнд:

10.1. “Хариуцлагатай ажил олгогч-Бүтээмжтэй ажилтан” төсөл боловсруулан хэрэгжүүлэх

10.2. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өнөөгийн байдал, хэтийн хандлагын талаар дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох

10.3. байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх

10.4. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх богино хэмжээний кино, шторк, видео хичээлүүдийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах

10.5. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд холбогдох байгууллагуудтай хамтран үзлэг хийх, гарсан зөрчлийг арилгуулах талаар хамтран ажиллах

10.6. Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар аж ахуй нэгж байгууллагын ажилтан, ажил олгогч нарыг чадавхжуулах сургалт семинар зохион байгуулах

10.7. Малчид хоорондын хөдөлмөрийн харилцааг сайжруулах

10.8. Хөдөлмөрийн бүтээмжийн тухай олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан цалин хөлсний тогтолцоог хэрэгжүүлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, сургалт, сурталчилгаа хийх

10.9. Хөдөлмөрийн харилцааны асуудлаар нийгмийн түншлэлийн байгууллагуудтай хамтарч ажиллах, орон нутагт нийгмийн түншлэлийг хөгжүүлэх

Зорилт-11 Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн санд бүртгэлтэй ажил идэвхтэй хайгч иргэдийг ажлын байраар хангах

Үр дүн: Аймаг орон нутгийн хэмжээнд хэрэгжих бүтээн байгуулалтын ажилд ажил хайгч иргэдийг зуучилснаар ажлын байр нэмэгдэнэ.

Зорилт 11-ийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа. Үүнд:

11.1. Угалз 4-р багт спорт заал бүхий Багийн хөгжлийн төв барихад багийн мэргэжлийн болон туслах ажилтныг авч ажиллуулах

11.2. Аймгийн Засаг даргын Тамгын газар, Чандмань-Баянхонгор ХК-ний цэцэрлэг байгуулахад цэцэрлэгийн багш болон туслах багш, үйлчилгээний чиглэлээр ажил хайгч иргэдийг байнгын ажлын байранд зуучлах

11.3. Ойн зурvas байгуулах, нийтийн эзэмшлийн талбайд ногоон байгууламж байгуулахад ажил хайгч иргэдийг түр ажлын байраар хангах

11.4. “Ажилсаг төв-үйлдвэр, технологийн парк”-ийг түшиглэн ажлын байрыг нэмэгдүүлэх

11.5. “Баянхонгор Нью майнинг”ХХК-ний хүрээнд шинэ ажлын байрыг нэмэгдүүлэх
11.6. Баянхонгор-Байдрагийн хатуу хучилттай авто замыг барихад орон нутгийн иргэдийг ажиллуулж, түр ажлын байраар хангах

11.7. Баянхонгор сумын 5-р сургууль, шинэ цэцэрлэгүүдийг ашиглалтад оруулж байнгын ажлын байраар мэргэжилтэй ажиллах хүчинг хангах

ТАВ. ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМУУД

5.1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар болон төрийн бусад агентлаг, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК, хувийн хэвшил, нийгмийн түншлэл, иргэний байгууллага, иргэдийн оролцоотой хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх замаар бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах.

5.2. Хөтөлбөрийг орон нутгийн бусад салбарын бодлоготой уялдуулж хэрэгжүүлэх

5.3. Хөтөлбөрийн үе шат бүрт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталж, шаардагдах хөрөнгийг аймгийн жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсөвт тусган төлөвлөж хэрэгжүүлэх

5.4. Хөтөлбөрийн үйл ажиллагааны явцад хяналт шалгалтын үнэлгээ хийж, тухайн жилийн хэрэгжилтийг дараа жилийн эхний сарын 20-ны дотор багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байх

5.5. Хөтөлбөрийг 2017-2021 он хүртэл хүн амын хэтийн төлөв, хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт, эдийн засаг, нийгмийн хөгжилтэй уялдуулан 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

5.6. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр гаргаж, аймгийн Засаг даргын захирамжаар батлуулж хэрэгжүүлнэ.

5.7. Аймаг орон нутгийн жил бүрийн төсөв, сум хөгжүүлэх сан, хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас тодорхой зардлыг санхүүжүүлэх замаар хэрэгжүүлэх.

ЗУРГАА.ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэх ба үе шат бүрт хүрэх үр дүнг тодорхойлно.

6.1.1. Хөдөлмөрийн хүмүүжил, соёл төлөвшине.

6.1.2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүү багассан байна.

6.1.3. Зохистой хөдөлмөр эрхлэлт нь эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг дэмжсэн байна.

6.1.4. Хөдөлмөр эрхлэлтийн зорилтот бүлэг 10 хувиас доошгүй буурсан байна.

6.1.5. Хөдөлмөрийн нөөц зохистой ашиглагдсан байна.

6.1.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл сайжирсан байна.

6.2. Бодлогын үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:

6.2.1. Хөдөлмөр эрхлэлт нь эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг бий болгосон байна. Үүнд:

6.2.1.1. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин

6.2.1.2. Ажилгүйдлийн түвшин

6.2.1.3. Хөдөлмөрийн бүтээмж

6.3. Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын эзлэх хувь

6.3.1. Хөдөлмөр эрхлэлтийн зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт 10 хувиар нэмэгдсэн байна. Үүнд:

6.3.2. Нийгмийн даатгалд хамрагчдын тоо

6.3.3. Татвар төлөгчдийн тоо

6.3.4. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур орлоготой ажиллагсдын эзлэх хувь

6.3.5. Хувиараа болон өрхийн аж ахуй эрхлэгчдийн хувь

6.3.6. Мал аж ахуй эрхлэгчдийн хувь

6.3.7. Газар тариалан эрхлэгчдийн хувь

6.4. Хөдөлмөрийн нөөц зохистой ашиглагдсан байна. Үүнд:

6.4.1. Ажиллах хүчиний оролцооны түвшин

6.5. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн зөрүү багассан байна. Үүнд:

6.5.1. Ажлын шинэ байрны тоо

6.5.2. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин

6.5.3. Байнгын ажлын байрны тоо

6.6. Бодлогын хэрэгжилтийг Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн

түвшин, хөдөлмөрийн бүтээмж гэсэн үзүүлэлтээр үе шат бүрээр дүгнэсний үндсэн дээр дараагийн шатны үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлнэ.

**ДОЛОО.ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

7.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль, тогтоомж, бусад эрх зүйн актууд болон хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон баримт бичгийн дагуу зохион байгуулагдана.

7.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр гаргаж хэрэгжүүлэн, үр дүнг хянаж ажиллана.

7.3 Удирдлага зохион байгуулалт:

Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд эдийн засаг, хөрөнгө оруулалт, нийгэм, хөдөө аж ахуйн бусад төсөл хөтөлбөр, төсвийн санхүүжилттэй нягт уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцна.

Хэлтэс агентлагууд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран оролцно.

Хөтөлбөрийн явц, үр дүн, гүйцэтгэлийг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх ба санал боловсруулж, Засаг даргын зөвлөлд танилцуулна.

7.4. Аймгийн ажлын хэсэг дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

7.4.1 Хөтөлбөрт тодорхойлсон зорилт, бодлого арга хэмжээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлуулан Засаг даргын захирамж гаргуулж, хэрэгжилтийг хангуулах

7.4.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний төлөвлөгөөт жилийн хэрэгцээ-захиалгыг хөдөлмөрийн зах зээлийн байдалд хийсэн дүн, шинжилгээ, судалгаанд үндэслэн төлөвлөж хэрэгжүүлэх

7.4.3 Сум, орон нутгийн түвшинд хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллага, ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт хийж, үнэлгээ өгөх

7.4.4 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өмчийн бүх хэлбэрийг үл харгалzan татан оролцуулах, тэдгээртэй ажил хэргийн холбоо, хамтын ажиллагаа-түншлэлийг бэхжүүлэх, урамшууллын сонвчтой механизмыг бүрдүүлэх

7.4.5 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл, тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж, шаардлагатай тохиолдолд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах

7.2.1. Сумын ажлын хэсэг дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

7.2.1.1 Ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгах чиглэлээр тухайн жилд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгагдсан шинэ ажлын байр бий болгох чиглэлээр дэвшиүүлсэн зорилтыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх

7.2.1.2 Ажлын байр бий болгох, жижиг үйлдвэр, бизнесийг дэмжих зориулалтаар сумдаа хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж, үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах

7.2.1.3 Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдсон судалгаа, мэдээ, тайланг аймгийн ажлын хэсэгт жил бүрийн 11 дүгээр сард багтаан гаргаж ирүүлэх

НАЙМ. ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ

8.1 Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- 8.1. Улсын төсвөөс аймагт хуваарилсан хөрөнгө
- 8.2. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө
- 8.3. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хүрээнд хуваарилсан хөрөнгө
- 8.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвлөрсөн сангаас аймагт хуваарилсан хөрөнгө
- 8.5. Хандивлагч орон, Олон улсын байгууллагын зээл, тусlamж
- 8.6. Аж ахуй нэгж, иргэд, төрийн бус байгууллагын санаачлагаар бүрдүүлсэн тусlamж, хандивын хөрөнгө, тэтгэлэг
- 8.7. Банкны зээл, хувийн хөрөнгө оруулалт
- 8.8. Аж ахуй нэгж байгууллага, иргэдийн өөрийн хөрөнгө
- 8.9. Бусад эх үүсвэр

ЕС. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт, үнэлгээ хийх ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг эрхлэн гүйцэтгэнэ.

9.2. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ хийх ажлын хэсэгт ажил олгогч эзэд, Үйлдвэрчний эвлэл, Мэргэжлийн холбоод, иргэд, төрийн байгууллагын төлөөллийг оролцуулсан байна.

9.3. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээний ажлын зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, туршлага, сургамжийг нэгтгэн дүгнэх, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулсан хөрөнгө хүндээ хэрхэн хүрч зохих дэмжлэг болж чадсаныг судалгаа, шинжилгээ, олон нийтийн оролцооны аргаар тогтоох, цаг үеийн байдалтай холбогдуулан хөтөлбөрийг шинэчлэн сайжруулахад оршино.

9.4. Хэрэгжилтийн үнэлгээний арга хэлбэр, үе шат

9.4.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт тусгагдсан зорилтын хэрэгжилтийн явцад төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шат бүрд үнэлгээ хийнэ. Үүнд:

- 1-р үе шат буюу 2017-2018 он
- 2-р үе шат буюу 2019-2021 он

9.5. Явцын үнэлгээ буюу мониторингийг 2 жил тутамд зохион байгуулж, дүнг мэдээлж ажиллана.

9.6. Төлөвлөгөөний биелэлтийн явцыг аймгийн ажлын хэсэг, аймгийн Засаг дарга болон Засаг даргын зөвлөлд мэдээлж, тайлагнах ба аймгийн Засаг даргын Тамгын газар иргэдэд мэдээллэх, сурталчлах ажлыг хариуцан зохион байгуулна.

9.7. Биелэлтийн явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Засаг дарга холбогдох байгууллагад уламжилж, шийдвэрлүүлж ажиллана.

АРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

10.1. Монгол Улсын Үндсэн хууль
10.2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

10.3. Төрийн албаны тухай хууль
10.4. Нэгдсэн төсвийн тухай хууль
10.5. Боловсролын тухай хууль
10.6. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
10.7. Хөдөлмөрийн тухай хууль
10.8. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
10.9. Концессийн тухай хууль
10.10. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
10.11. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод сууринсан үндэсний хөгжлийн цогц бодлого

10.12. Хуульд нийцүүлэн гаргасан Засгийн газар, яам, тусгай газрын журам, тогтооцууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, бусад шийдвэрүүд байна.